



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 674

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

**БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ  
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн  
талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Д.Чойжамцын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021351

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Д.Чойжамц Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Д.Чойжамцын мөрийн хөтөлбөр (.../.....хуудас) -ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Д.Чойжамцын

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

**2024-2028 оны орон нутгийн ИТХ-ын сонгуульд бие даан нэр дэвшиж буй Доржсүрэн овогтой Чойжамц мөрийн хөтөлбөрий жагсаалт**

Эрүүл мэнд, боловсрол

1. Шүдний үзлэгт хамрагдаж буй иргэдийн судалгааг гаргах
2. Хорт хавдрын үзлэгт хамрагдсан иргэдийн тоо үзүүлэлт дээр хяналт тавих
3. Их дээд сургуульд сурч байгаа оюунтыг тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахыг уриалах
4. ЕБС-ийн сургалтыг тэгш хүртээмжтэй хүргэхэд анхаарах

Мал аж ахуй, газар тариалан

1. Малын үүлдэр угсааг сайжруулах үйл ажиллагааг хянах
2. Малын халдварт өвчнөөс сэргийлэх сургалтын иргэдийн дунд зохион байгуулах, зөвлөгөө өгөх
3. Бэлчээрийн даацыг хянах
4. Төмс хүнсний ногоог өвөлжөө хаваржааны бууцанд тарьж ургуулж өрхийн хэрэгцээгээ хангахыг малчдад заах өгөх, зөвлөх

Байгаль орчин

1. Улаан номонд орсон ургамлыг хамгаалтад авах үйл ажиллагааг ард иргэдтэй хамтран зохион байгуулах
2. Балигийн голын урсацыг далан барих аргаар нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах
3. Ховор, нэн ховор амьтдыг хамгаалах үйл ажиллагааг байгаль хамгаалагч нартай хамтран хийх
4. Ой мод нөхөн сэргээх, хортон шавжийг устгах үйл ажиллагааг мэргэжлийн ой ангитай хамтран зохион байгуулах

Жижиг дунд үйлдвэрлэл

1. Арьс, шир элдэх цех орчин үеийн технологи нэвтрүүлэх ажиллагаанд туршлага түгээн дэлгэрүүлэх
2. Сүү цагаан идээ савлах, борлуулах үйл ажиллагаанд хяналт тавих, хамтран ажиллаха
3. Нутгийн бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүсэлттэй иргэдийг саналыг авах

Мөрийн хөтөлбөр боловсруулсан:

Д. Чойжамц

Холбоо барих утас:86563308